



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/3/НА-СТА-ОНӨААТҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: Erdene.b@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

-
1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжий хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
 5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.03.15 № 286
танай _____ ны № _____ т

“ТЭШИГ-УС” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ П.ОЮУНБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт 103.5 хувийн биелэлттэйгээр тайлагнасан, сумын Засаг даргатай байгуулсан контрактын гэрээний хэрэгжилтийг 94.0 хувьтай дүгнэсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 421,739.5 төгрөг болж, төлөвлөснөөс 23,371.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь өмнөх оны өглөг барагдуулах хөрөнгийг төсөвт тусгаагүйгээс шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

2022 онд үйл ажиллагааны орлогоос 412,586.1, урьд оны үлдэгдлээс 20,805.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж үндсэн үйл ажиллагааны орлого 14,185.6 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

006020270

Авлага данс өмнөх оноос 2,239.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн, өглөгийг дансны эхний үлдэгдэл 44,273.0 мянган төгрөгөөс 21,758.4 мянган төгрөгийг барагдуулж, 21,456.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2022 санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,842,308.93	47,791,910.48
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,805,865.48	21,822,789.56
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	16,842.47	195,742.47
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	20,789,023.01	21,627,047.09
31210	Төгрөг	20,789,023.01	21,627,047.09
31211	Төрийн сангийн харилцах	0	0
31212	Монгол банкин дахь харилцах	0	0
31213	Арилжааны банк дахь харилцах	20,789,023.01	21,627,047.09
33	АВЛАГА	7,608,503.45	9,847,699.50
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	38,459.79	88,627.29
33500	Бусад авлага	7,570,043.66	9,759,072.21
33510	Байгууллагаас авах авлага	5,120,890.66	7,309,919.21
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,449,153.00	2,449,153.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13,427,940.00	16,121,421.42
35100	Түүхий эд материал	27,200.00	70,150.00
35110	Тусгай зориулалттай материал	0	0
35130	Эм боох материал	27,200.00	70,150.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	0	0
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,190,860.00	1,805,181.12
35400	Хангамжийн материал	10,209,880.00	14,246,090.30
35410	Бичиг хэргийн материал	555,500.00	272,426.41
35420	Аж ахуйн материал	78,800.00	61,177.79
35430	Сэлбэг хэрэгсэл	1,695,000.00	2,163,727.16
35440	Түлш, шатах тослох материал	299,400.00	622,570.45
35450	Барилгын засварын материал	0	0
35460	Хүнсний материал	1,161,885.00	1,481,972.41
35470	Бусад хангамжийн материал	6,419,295.00	9,644,216.08
36900	БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	0	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,167,096.60	5,072,670.73
37330	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0	0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,167,096.60	5,072,670.73
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	18,167,096.60	5,072,670.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	54,100,000.00	50,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,987,319.43	-50,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	8,637,330.23	8,637,330.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	-6,062,370.90	-7,142,037.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,312,900.00	4,312,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,097,146.67	-2,613,921.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,414,944.00	4,249,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,151,240.63	-2,371,400.65
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	60,009,405.53	52,864,581.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	44,273,021.19	21,456,243.42
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	44,273,021.19	9,847,699.50
41300	Өглөг	44,273,021.19	21,456,243.42
41360	Бусад өглөг	44,273,021.19	21,456,243.42
41361	Байгууллагад төлөх өглөг	28,621,925.05	13,037,524.22
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	370,818.94	253,718.56
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	15,280,277.20	8,123,708.77
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0	41,291.87

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,736,384.34	31,408,337.79
51	Засгийн газрын хувь оролцоо	15,736,384.34	31,408,337.79
51200	Хуримтлагдсан үр дүн	15,736,384.34	31,408,337.79
51210	Өмнөх үеийн үр дүн	-27,452,743.81	15,736,384.34
51220	Тайлант үеийн үр дүн	43,189,128.15	15,671,953.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	60,009,405.53	52,864,581.21

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	296,099,553.24	382,171,218.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	296,099,553.24	382,171,218.53
120	Нийтлэг татварын бус орлого	296,099,553.24	382,171,218.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	373,559,378.86	382,171,218.53
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	373,448,828.86	382,171,218.53
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	110,550.00	0
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	77,459,825.62	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	252,747,981.09	364,930,634.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	252,747,981.09	364,930,634.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	252,047,981.09	363,630,634.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,058,166.94	116,657,949.00
210101	Үндсэн цалин	110,058,166.94	116,657,949.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,922,122.18	15,495,197.61
210201	Тэтгэврийн даатгал	14,922,122.18	15,495,197.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,163,395.49	31,681,099.26
210301	Гэрэл, цахилгаан	25,163,395.49	31,681,099.26
2104	Хангамж, бараа материалын зардал	49,318,038.09	134,310,916.84
210401	Бичиг хэрэг	710,364.54	1,674,956.31
210402	Тээвэр, шатахуун	48,339,491.76	132,335,960.53
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	268,181.79	300,000.00
2105	Нормативт зардал	4,858,761.50	4,887,878.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	22,050.00
210502	Хоол, хүнс	4,858,761.50	4,865,828.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,082,055.83	14,732,712.62
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	846,500.00	951,590.55
210604	Урсгал засвар	2,235,555.83	13,781,122.07
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	2,274,000.00
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	2,274,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,485,477.43	32,065,085.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,764,000.00	3,025,500.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	119,660.00	97,750.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	7,599,564.30	18,600,000.00
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	0	0
210813	Бусад зардал /ТӨҮГ/	18,081,300.00	8,600,506.92
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	4,920,953.13	1,741,328.16
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,159,963.63	11,525,795.56
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,159,963.63	11,525,795.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	700,000.00	1,300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.00	1,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	1,300,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	43,351,572.15	17,240,583.76
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	162,444.00	1,568,630.31
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	162,444.00	1,568,630.31
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	43,189,128.15	15,671,953.45

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	-34,827,206.46	-34,827,206.46
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	7,374,462.65	7,374,462.65
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	-27,452,743.81	-27,452,743.81
9	Тайлант үеийн үр дүн	0	43,189,128.15	43,189,128.15
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	15,736,384.34	15,736,384.34
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	15,736,384.34	15,736,384.34
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	15,736,384.34	15,736,384.34
19	Тайлант үеийн үр дүн	0	15,671,953.45	15,671,953.45
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	31,408,337.79	31,408,337.79

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	410,592,699.41	422,756,391.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	410,592,699.41	422,756,391.12
120	Нийтлэг татварын бус орлого	410,592,699.41	422,756,391.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	410,592,699.41	422,756,391.12
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	397,779,151.41	417,369,786.12
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,813,548.00	5,386,605.00

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	387,860,411.38	421,739,467.04
299990	Устгал	0	0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	387,860,411.38	421,739,467.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387,860,411.38	421,739,467.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,058,166.94	96,710,990.38
210101	Үндсэн цалин	110,058,166.94	96,710,990.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,922,122.18	28,216,953.74
210201	Тэтгэврийн даатгал	14,922,122.18	28,216,953.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,679,735.02	31,681,099.26
210301	Гэрэл, цахилгаан	27,679,735.02	31,681,099.26
2104	Хангамж, бараа материалын зардал	164,899,105.00	191,413,324.82
210402	Тээвэр, шатахуун	2,671,234.00	10,276,894.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	162,227,871.00	181,136,430.82
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,128,886.24	49,536,448.84
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	49,128,886.24	49,536,448.84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,172,396.00	24,180,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,172,396.00	24,180,650.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	22,732,288.03	1,016,924.08
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,639,800.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,639,800.00	0
2200	Дотоод эх үүсвэрээр	2,639,800.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,639,800.00	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,639,800.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	20,092,488.03	1,016,924.08
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	713,377.45	20,805,865.48
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,805,865.48	21,822,789.56

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	119,970,000	116,657,949.00	3,312,051.00
2	Байгууллагаас төлөх ЭМНДШ	17,395,650	15,495,197.61	1,900,452.39
3	Цахилгааны өөрийн хэрэглээ	28,090,349	31,681,099.26	(3,590,750.26)
4	Түлш шатахуун	2,400,000	3,622,444.85	(1,222,444.85)
5	Албан томилолт	2,206,000	2,274,000.00	(68,000.00)
6	Утас, /Интернет/	300,000	300,000.00	-
7	Нүүрс мод, тээвэр зардал	147,300,000	146,713,515.68	586,484.32

8	Ариутгал цэвэрлэгээ	675,000	755,368.92	(80,368.92)
9	Бичиг хэргийн зардал	1,078,600	1,674,956.31	(596,356.31)
10	Хөдөлмөр хамгаалал	1,200,000	951,590.55	248,409.45
11	Эм хангамж	160,000	22,050.00	137,950.00
12	Лабортори шинжилгээ	380,000	380,000.00	-
13	Гадны үйлчилгээний хөлс	3,050,000	3,025,500.00	24,500.00
14	Даатгалын зардал	800,000		800,000.00
15	Хүнсний зардал	5,252,000	4,865,828.80	386,171.20
16	Сэлбэг хэрэгсэлийн зардал	2,000,000	744,000.00	1,256,000.00
17	Хангамж	4,260,000	2,677,531.07	1,582,468.93
18	Гүйцэтгэх удирдлагын зардал	2,000,000	2,000,000.00	-
19	ТУЗ-н зардал	400,000	400,000.00	-
20	Тэтгэмжийн зардал	1,200,000	1,200,000.00	-
21	Үндсэн хөрөнгө бэлтгэх зардал	15,000,000	15,003,591.00	(3,591.00)
22	Төлөх татвар	43,250,861	49,536,448.84	(6,285,587.84)
23	Урд оны өглөг барагдуулсан		21,758,395.15	(21,758,395.15)
		398,368,460	421,739,467	(23,371,007.04)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт ... сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 11525.7 төгрөгийн алдааг залруулж, 8123.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

Үүнд: Үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдэл 11525.7 мянган төгрөгийг тооцоогүй, тайланд тусгаагүй нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.35-д "Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 1887.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1887.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

Байхгүй.

3.2 Албан шаардлага

1. Санхүүгийн тайлан дахь авлага дансанд 1887814 төгрөгийн өмнөх онуудын авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь НББ-ийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Шилэн дансны цахим хуудсанд 8 мэдээлэл хугацаа хоцроосон, мөн төсөв өмч, хөрөнгийн зарцуулалттай холбоотой тушаал шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НБББББ-тай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын НБББББ-ийг 2018 онд захирлын тушаалаар баталж үүнээс хойш шинээр баталсан хууль тогтоомж, санхүүгийн бүртгэлтэй тохируулан баяжилт хийгдээгүй нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: НБББББ-ийг шинээр мөрдөгдөж буй хууль тогтоомжтой нийцүүлэн баяжилт хийх.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ТУЗ компанийн дүрэм болон холбогдох эрх зүйн актуудад тусгагдсан үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй.

Өгсөн зөвлөмж: Компани дүрэм, холбогдох хууль тогтоомжид заасан үүргийг бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийг баримтжуулж байх.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2022 оны татварын өглөгийн 15280277 төгрөгөөс тайлант онд 7156568 төгрөгийг барагдуулж санхүүгийн тайланд 8123708 төгрөгийн өр байгаа нийт өрийн 37.8 хувийг татварын өр эзэлж байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д "Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын болон бусад өр төлбөрийг төсөвт тусган бүрэн барагдуулах арга хэмжээ авах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруулаагүй	
				Н	ҮЙ	

